



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн захиргааны нэгдсэн байр,
Баянголын гудамж 1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: (976) 7017 0109
Цахим хуудас: www.shd.mn

2025.12.25	№	03/4225
танай	-ны №	-т

「НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН」
ДАРГА Д.МӨНХЧУЛУУН ТАНАА

Соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх үйл хэрэгт идэвх санаачилгатай оролцсон, өөрийн өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн, залуу хойч үедээ өвлүүлэн, уламжлуулж буй дүүргийн 33 дугаар хорооны иргэн Д.Балганыг 2025 оны “Шилдэг өвлөн уламжлагч”-д нэр дэвшүүлэн уламжилж байна.

Хавсралт 18 хуудастай.

Д.БАЛГАН

YA TACPAK OB

ХОТОН УГСААТНЫ БИЙ БИЕЛГЭЭ



செவ்வாய்

1. ТАНИЛЦУУЛГА

МУСТА, Монгол улсын батламжит өв уламжлагч, бий биелээч, онц тээвэрчин, 13 дахь үеийн соёлын биет бус өв уламжлагч Хотон ястан Шаавай овогт Дурмагийн Балган нь Хотон ястны уламжлалт бий биелгээг аав, ээж, авга, нагацаасаа уламжлан сурсан цагаасаа эхлээд өдгөө хүртэл өвлөн уламжлахдаа өөрийн үр хүүхдүүдэд өвлүүлэхээс гадна Монгол улсын өнцөг булан бүрт түгээн дэлгэрүүлэх үйлсийг амжилттай хэрэгжүүлж байгаа Монгол Улсын шилдэг өв тээгч мөн билээ. Монгол улсын соёлын өвийн үндэсний төвөөс хэрэгжүүлдэг олон арга хэмжээнд өөрөө болон үр хүүхдүүдтэйгээ хамтдаа оролцож байдаг.

Д.Балган нь Хотон биелгээний өөрийн гэсэн уламжлалт дэг сургалтыг үүсгэхдээ хадам аав Х.Түвдэнгийн бий биелгээг хийхэд биед нөлөөлөх нөлөө, мэдрэмж бүхнийг өөртөө бий болгох арга барилыг уламжлан авч өдгөө хүртэл бусад ястны биелгээтэй харьцуулан судлахын зэрэгцээ үргэлж шинийг эрэлхийлэн хайж байдаг зан чанар нь түүний үр хүүхдүүдэд бүрэн шингэсэн байдаг. 2009 онд ЮНЕСКО-оос Монголын уламжлалт бүжиг бий биелгээг “Яаралтай хамгаалах соёлын биет бус өв”-ийн дэлхийн жагсаалтад бүртгүүлэх үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулж, утга соёлын өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авьяастны улсын жагсаалтад бүртгэгдсэн Монгол улсын шилдэг өв уламжлагч билээ.

2. НАМТАР

- Төрсөн огноо: **1960 оны 07 сарын 29**
- Төрсөн газар: **Увс аймаг Тариалан сум**
- Боловсрол: **Бүрэн дунд**
 - 1969 онд Увс аймгийн Улаангом сумын 1-р арван жилийн сургуульд элсэн орж 1976 онд төгссөн.
 - 1976-1978 онд Өвөрхангай аймгийн Улсын аж ахуйн ТМС-ыг **гүний өрөмдлөгийн мэргэжлээр** суралцан төгссөн.
- Эзэмшсэн мэргэжил: **Авто агрегат засварчин.**
- Өвлөсөн авьяас: Хотон ястаны **бий биелгээ, икэл хуурын** татлагыг аав Дурмаг болон авга, нагац нараараа заалгаж сурсан. **13 дахь үеийн өв уламжлагч.**
- Гэр бүлийн байдал: эхнэр, 6 хүүхэд, 6 ач, 11 зээтэй

Тэрээр 1983 онд Хольдог овогт Түвдэнгийн Сэтэнтэй гэр бүл болж 6 хүүхдийн аав ээж болсон байна. Өдгөө ач, зээ нийлээд 28-уулаа өнөр өтгөн сайхан амьдарч үр, ач, зээ нартаа өвөг дээдсээс өвлөсөн бий биелгээ, икэл хуурын татлагаа үе уламжлуулан өвлүүлж байна. 1984 онд авто тээврийн байгууллага үүсэж хөгжсөний 50 жилийн ойн урлагийн үзлэгт ардын язгуур урлагийн бий биелгээний төрлөөр оролцож хүрэл авч эхлэснээс хойш өдгөө хүртэл улсын хийгээд олон улсын уралдаан тэмцээн бүрт амжилт гаргасаар явна.

2025 оны байдлаар дүгнэн үзэхэд 1999 оноос гэр бүлийн “АЯС” хамтлагийг үүсгэж өөрийн үр хүүхдүүддээ Хотон угсаатны бий биелгээ, иклийн татлагыг зааж сургасан нь хожмоо түүний үр хүүхдүүдийн өсөн дэвжих их замын эхлэл болсон байдаг. Энэ ч үүднээс тэдний гэр бүлд Монгол Улсын Соёлын Тэргүүний ажилтан 4, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны жуух бичигтэн 1, тэргүүний ардын авьяастан 3 төрсөн нь Д.Балганы гэр бүлийн амжилтын хамгийн оргил хэсэг билээ.

Түүний энэхүү өвлөсөн авьяасыг том хүү Б.Чулуунбаатар нь Увс аймгийн хүүхэд багачуудад үлгэрлэн үзүүлж, сурган хүмүүжүүлж яваа бол хүү Б.Гүрбазар, Б.Ганзориг, Б.Золжаргал нар нь ардын язгуур урлагийн “Алтай” хамтлагт ажиллаж олон түмний хүртээл болгон эртний нүүдэлчдийн өв соёлыг гүнзгийрүүлэн судалж Монгол улсдаа болон олон улсад Монголчуудын эртний язгуур өвүүдийг түгээн сурталчилж байна.

Охин Б.Бүзмаа, Б.Цэнгэл нар нь өөрийн хүүхдүүддээ бий биелгээг уламжлуулан зааж зээ нар нь энэхүү өвийг өөрсдийн сургууль, цэцэрлэгтээ танилцуулж байна. МУСТА, Монгол улсын батламжит өв уламжлагч Д.Балган нь Хотон бий биелгээг ийнхүү олон жил судлахдаа Хотон ястаны бий биелгээний амин чанар, гүн ухаан, хөдөлгөөний онцлог зэргийг бусад ястнуудын бий биелгээтэй харьцуулан судалж, сургалт судалгааны ажилд оруулах зэргээр ажиллаж өөрийн үйл хэргийг үр хүүхдүүддээ өвлүүлж цаашид судлуулан ажиллаж байна.

- 13 дахь үеийн соёлын биет бус өвийн **өвлөн** уламжлагч. Хотон **угсаатны** уламжлалт бий биелгээг аав, ээж, авга, нагацаасаа уламжлан сурсан цагаасаа эхлээд өдгөө хүртэл өвлөн уламжлахдаа өөрийн үр хүүхдүүдэд өвлүүлэхээс гадна Монгол улсын өнцөг булан бүрт түгээн дэлгэрүүлэх үйлсийг амжилттай хэрэгжүүлж **2500 гаруй шавь төрүүлж, 42 жил Хотон угсаатны бий биелгээг бийлж байна.**
- 2009 онд ЮНЕСКО-оос Монголын уламжлалт бүжиг бий биелгээг “Яаралтай хамгаалах соёлын биет бус өв”-ийн дэлхийн жагсаалтад бүртгүүлэх үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулсан.
- Засгийн газрын **2019 оны 475 дугаар тогтоол**–ын дагуу Соёлын биет бус өвийг өндөр ур чадвартай өвлөн уламжлагчдыг үндэсний жагсаалтад бүртгэгдсэн.
- Хотон биелгээний өөрийн гэсэн уламжлалт дэг сургалтыг үүсгэхдээ хадам аав Х.Түвдэнгийн бий биелгээг хийхэд биед нөлөөлөх нөлөө, мэдрэмж бүхнийг өөртөө бий болгох арга барилыг уламжлан авч өдгөө хүртэл бусад угсаатны биелгээтэй харьцуулан судалж ирсэн.
- 2023 онд “ҮЛ ТАСРАХ ӨВ” хотон угсаатны бий биелгээний сургалтын гарын авлагыг бүтээж олон нийтэд хотон бий биелгээг түгээн дэлгэрүүлэх ажлаа эрчимжүүлж байна. Д.Балганы бүтээсэн “Үл тасрах өв” Хотон бий биелгээний гарын авлага ном нь Хотон угсаатны түүх соёл, зан үйл түүний дотроос Хотон бий биелгээг хэрхэн бийлэх, түүний бусдаас ялгарах онцлогийг нарийн гаргаж бичсэн нь өнөө цагийн хувьд бий биелгээг өвлөн уламжлагчдаас гаргаж буй хамгийн анхны ном гэдгээрээ илүүтэй онцлог юм. Уг ном нь дөрвөн бүлэг, найман зүйлээс бүрдэнэ. Номд соёлын өвийн тухай мэдлэг мэдээлэл, Монголын уламжлалт бий биелгээний түүхийн тухай, Хотон угсаатны түүх, соёлын тухай ойлголт, Хотон биелгээг хийх аргачлалыг нарийн харуулсны дээр өөрийн оршин амьдарч байгаа газар нутгийн

соёлын биет өвүүд болон Хотон угсаатны алдарт бийчдийн талаарх товч мэдээллийг оруулсан гарын авлага юм.

- Франц улсын иргэн, бүжиг судлаач доктор Рафаел Бланчер нь 2012 оноос хойш өнөөг хүртэл Монголын уламжлалт бүжиг бий биелгээг судлахдаа судалгааныхаа гол суурийг Д.Балганы гэр бүлд тулгуурлан авч өөрийн судалгааг хийж тэрхүү судалгаагаараа олон улсын бүжиг судаллаар докторын зэрэг хамгаалж тэр үеэс эхлээд багш шавийн барилдлага тогтоож одоог хүртэл хамтран ажилласаар байгаа нь Монгол уламжлалт бий биелгээ, Хотон угсаатны бий биелгээг судалгааны эргэлтэд оруулах, хадгалж хамгаалах, олон улсад сурталчилан таниулахад онцгой үүрэг гүйцэтгэж байна.

➤ 2025 онд хийгдсэн үйл ажиллагаанууд



5 оны 01 сарын 03-нд
Соёлын Өвийн
Үндэсний Төвийн “Өв
Эрдэнэ” театрт “Үл
тасрах өв” төслийн
хүрээнд “УГСААТНЫ
БИЙ БИЕЛГЭЭНИЙ
ӨӨР ӨӨРИЙН
ОНЦЛОГ ШИНЖ,
ОЛОН ТАЛТ
БАЙДАЛ”

хэлэлцүүлэг, номын
өдөрлөгийг
амжилттай зохион байгуулсан билээ. Уг арга
хэмжээг нээж СӨҮТ-ийн дарга Г.Энхбат,
Нийслэлийн Соёл Урлагийн Газрын
Соёлын хэлтсийн дарга Г.Жанцансамбуу
нар нээсэн бөгөөд МУСГЗ С.Юндэнбат,
Захчин угсаатны алдарт бийч
Ш.Отгонбаяр, Торгууд угсаатны алдарт
бийч Д.Чулуунбат, Дархад угсаатны
алдарт дууч Б.Дариймаа нар хүрэлцэн
ирж өөрийн сэтгэгдлээ илэрхийлсэн
билээ. Мөн уг арга хэмжээнд СУИС Соёл
Судлалын Хүрээлэнгийн захирал
Ш.Эрдэнэцэцэг “БИЙ БИЕЛГЭЭГ
УЛАМЖИЛЖ БУЙ ХЭЛБЭР,



ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОНЦЛОГ ШИНЖ”сэдвээр, “Хүн” театрын үүсгэн байгуулагч, МУГЖ, бүжиг дэглээч Я.Энхгэрэл “ОЙРАДЫН БИЙ БИЕЛГЭЭНИЙ ОНЦЛОГ ТАЙЗНЫ МОНГОЛ БҮЖИГТ ИЛЭРСЭН НЬ” (АЖ Д.Нанжидын “Ойрад биелэг”, МУГЖ Д.Будхүүгийн “Агсал” бүжгийн жишээн дээр) сэдвээр илтгэл тавьсан нь Монголын уламжлалт бүжиг бий биелгээний цаашдын хөгжлийг тодорхойлоход чухал ач холбогдол болсон юм. Мөн энэхүү арга хэмжээнд бусад өвлөн уламжлагчид ирснээс гадна нийслэлийн зургаан дүүргийн соёлын ордны ажилчид хүрэлцэн ирж Монголын соёлын биет бус өвийн цаашдын хөгжлийг хэрхэн хадгалж авч үлдэх, нийслэл хотод байгаа өвлөн уламжлагчдыг хэрхэн дэмжих талаар өөрсдийн санал хүсэлтээ хэлэлцлээ.

2. 2025 оны 07 сарын 17-19-ны өдрүүдэд Увс аймгийн Тариалан сумын нутаг Цалгар хэмээх газар Хотон угсаатны Шаавай овгийн Саарамбайн галын ураг удмын баярыг хийсэн нь түүний өвлөсөн энэхүү өв нь зөвхөн Д.Балганы гэр бүлд биш цаад удам угсаанд байгаагийн хамгийн том илрэл болж байгааг харуулж байгаа юм. Ингэснээр ураг удмын уялдаа холбоо, соёлын өвийн залгамжийг хадгалан үлдэхэд асар том гүүр болж байна.



2025 оны 07 сарын 22-нд Увс аймгийн Тариалан сумын түүхт 100 жилийн ой, 2025 оны 07 сарын 29-нд Увс аймаг байгуулагдсны түүхт 100 жилийн ойн баяр наадмын үйл ажиллагаанд урилгаар оролцож нутаг усны ахан дүүс, тэр нутгаас төрөн гарсан алдар цолтнуудын дунд өөрөө өөрийгөө авч явах, өөрийн өвлөсөн өвийг түгээн сурталчлах, хадгалан хамгаалах үйлс нь одоог хүртэл тасралтгүй явааг харуулсаар байна.




3. 2025 оны 08 сарын 16-17-ны өдрүүдэд Увс аймгийн Улаангом суманд ЮНЕСКО-ын Монголын Үндэсний Коммис, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам, Соёл Урлагийн Их Сургууль Соёл Судлалын хүрээлэнгээс хамтран зохион байгуулагдсан "Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд "МОНГОЛ БИЙ БИЕЛГЭЭ" наадмын бий биелгээний өвлөн уламжлагчийн төрөлд Хотон угсаатны бий биелгээгээр амжилттай оролцож тэргүүн байрын шагнал хүртэв.





4. 2024 оноос хойш тасралтгүй хийж байгаа түүний чухал ажлын нэг бол “Нүүдэлчин Монгол” дэлхийн соёлын наадам билээ. 2025 онд зохиогдсон “Нүүдэлчин Монгол” дэлхийн соёлын наадамд “Дээдэд Хөхрөгч Орон” НҮТББ, “Монгол улсын Мусульманы Худая нийгэмлэг” НҮТББ-тэй хамтран Хотон угсаатны овоо тахилгын зан үйл, түүний утга учрыг таниулан сурталчлах контент бүтээсэн нь Хотон угсаатны соёлын биет бус өвийг хадгалан хамгаалахад түүний хийж байгаа чухал үүрэг болж байна.





НҮҮДЭЛЧИН

ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ

ХОТОН УГСААТНЫ
ӨВ СОЁЛЫГ СУРТАЛЧИЛАХ ӨРГӨӨ

Нүүдэлчин 2024 дэлхийн фестивалд
Хотон угсаатны соёлыг сурталчлахаар
Монгол улсын батламжит өв тээгч,
Монгол улсын соёлын тэргүүний
ажилтан, Алтан Гадас одонт, Хотон
угсаатны алдарт бийч Д.Балганы
санаачлагаар зохион байгууллаа.

Энэхүү үйл ажиллагааны онцлог нь 2018
оноос хойш зохион байгуулагдаж байгаа
“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд
угсаатны зүгээс өөрсдийн соёлын
онцлогийг дэлгэн харуулсан угсаатны
хөтөлбөр байхгүй байсан ч Д.Балганы
санаачилсан “**Хотон угсаатны өв соёлыг
сурталчлах өргөө**” нь энэ бүхний анхдагч
болж чадсан юм.



Энэхүү хөтөлбөрөөр түүний 2023 онд бүтээсэн “Үл тасрах өв” Хотон угсаатны бий биелгээний номын нээлт, Хотон угсаатны шашны зан үйлийг танилцуулах “Тавгийн сан” буюу хийморийн сангийн зан үйл, Хотон угсаатны бий биелгээг танилцуулах хөтөлбөр зэргийг хэрэгжүүлсний дээр Хотон угсаатны хувцас хэрэглэл, идээ ундааны бүтээгдэхүүнээс дээжлэн үзүүлсэн нь уг фестивалийг үзэж сонирхож буй дотоодын үзэгчид болон гадны жуулчдын анхаарлыг татсан онц сонирхолтой үйл явдал болсон билээ.

Соёлын Өвийн Үндэсний Төвийн соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, баримтжуулан үлдээх санд Хотон угсаатнаас бий биелгээ, икэл хуурын татлага баримтжуулан үлдсэн байдаг боловч шашны зан үйлийн холбогдолтой баримт хараахан үлдээгүй байдаг. Харин энэхүү үйл ажиллагаагаар дамжуулж Хотон угсаатны шашны зан үйл “Тавгийн сан” буюу хийморийн сангийн зан үйл нь соёлын биет бус өвийн дөрөв дэх ай сав буюу Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйлд хамаарах болохыг баримтжуулан нотолж Соёлын Өвийн Үндэсний Төвийн архивд амжилттай үлдээж чадсан билээ.



“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцсон Хотон угсаатны өв соёлын хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээс авах боломжтой.

<https://www.facebook.com/photo?fbid=3739840776281583&set=pcb.3739847032947624>

<https://www.facebook.com/photo?fbid=3739919556273705&set=pcb.3739922162940111>

<https://www.facebook.com/100007670926308/videos/879714284027193>

- Наадмын эхний өдөр “Үл тасрах өв” Хотон угсаатны бий биелгээний гарын авлага номын нээлт боллоо. Нээлтэнд Соёлын Өвийн Төвийн дарга Б. Энхбат, МУСГЗ Ч.Даваасүрэн, Баруун Монголын алдарт дууч МУСТА Ж.Эрдэнэдалай, Увс аймгийн Тариалан сумын Соёлын төвийн эрхлэгч Х.Түмэнжаргал, Увс аймгийн Тариалан сумын Улаанбаатар хот, Орхон аймаг дахь нутгийн зөвлөл, болон Увс, Дархан-Уул, Орхон аймаг болон Улаанбаатар хот дахь Хотон угсаатны төлөөллүүд болон бусад угсаатны төлөөллүүд оролцлоо.



- Нүүдэлчин_2024 дэлхийн фестивалд Хотон Монголчуудын шашны зан үйл “Тавгийн сан” буюу хийморийн сангийн зан үйлийг толилуллаа. Зан үйлийг Соёлын өвийн төвийн Бүртгэл мэдээллийн газартай хамтран баримтжууллаа.



- Нүүдэлчин_2024 наадмын 2 дахь өдөр газар газраас цугласан хотонгууд маань өргөөндөө цугларч бийгээ бийлцгээлээ. Өнөөдөр 18 цагт Увс, Дархан, Сэлэнгэ

аймаг болон нийслэл хотоос цугларсан Хотон угсаатнуудын нэгдсэн тоглолт зохион байгуулагдана.



3. ГАВЬЯА ШАГНАЛ

➤ 2024 онд төрийн дээд “АЛТАН ГАДАС” одон.

- 2023 онд Монгол улсын засгийн газар, Соёлын Яамнаас зохион байгуулсан “НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2023” Дэлхийн соёлын наадамд бага хүү Б.Золжаргал, зээ хүү А.Тэмүжин нарын хамт амжилттай оролцсон.
/Доорх холбоосын 00:04:36-00:07:25 хүртэлх хэсгээс харж болно.
<https://www.facebook.com/D.Ganpurev/videos/601632288800647/>
- 2022 онд Монгол улсын засгийн газар, Соёлын Яамнаас зохион байгуулсан “НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2022” СББӨ-ийн их наадмын ардын язгуур урлагийн төрөлд “ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ”-аар батламжлагдсан.



- 2019 онд “Азийн ардын урлагийн их наадам”-ын ардын бүжгийн гоцлол төрөлд дэд байрын шагнал хүртсэн.



- 2019 онд ЮНЕСКО-д бүртгэгдсэн Монголын Соёлын биет бус өв маркт хэвлэгдэхэд Монголын уламжлалт бий биелгээний төлөөлөл болж марктмөнхлөгдсөн.



- 2018 онд “Нүүдэлчин Монгол” соёлын биет бус өвийн их наадамд зээ хүү А.Тэмүүжингийн хамт оролцож алтан медаль, өргөмжлөл болон БСШУЯ-ны “Соёлын биет бус өвийн шилдэг өв уламжлагчийг алдаршуулах” батламж хүртсэн.



- 2012 оны 5 сарын 28-нд Монгол Улсын БСШУЯ-аас Хотон ястны бий биелгээний уламжлалыг язгуур хэв шинжээр нь өвлөн хамгаалах, хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж оюун ухаан авьяас билэг олон жилийн бүтээлч хөдөлмөрөө зориулсныг үнэлж “Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн Монголын билэг авьяастнуудын улсын жагсаалт”-д бүртгэгдэж батламжлагдсан.
 - 2011 онд Ардын урлагийн их наадамд гэр бүлээрээ амжилттай оролцож тэргүүн дэд байр, “Мөнгөн-Од” медалиар шагнагдсан.
 - 2011 онд Монгол Улсын Засгийн Газрын шагнал “**Соёлын Тэргүүний Ажилтан**” цол тэмдгээр шагнагдсан.
 - 2011 онд Ардын Хувьсгалын 90 жил, Монгол Ардын Нам-90 жилийн медалиудаар тус тус шагнагдсан.
 - 2010 онд Монгол Улсын Засгийн Газрын хэрэг эрхлэх газар, Соёл Урлагийн Агентлагийн захиалгаар “Хотон түмний бий биелгээ” баримтат кинонд зөвлөх болон туслах найруулагчаар ажилласан.
 - 2010 оны 12 сард “Биеэр мэтгэсэн угалз” бий биелээчдийн улсын анхдугаар уралдаанд гэр бүлээрээ тэргүүн байр эзэлсэн.
 - 2009 онд Монгол Улсын “**Тэргүүний ардын авьяастан**” цолоор шагнагдсан.
 - 2007 Монголын Урлагийн Ажилтны Холбоо болон Монгол-Швейцарийн хөгжлийн сангаас хамтран явуулсан язгуур урлагийг өвлүүлэн сэргээх төслийн хүрээнд **бий, хуурын** төрлөөр шавь сургалт явуулах эрхээр батламжлагдсан.
 - 2007 онд Улаанбаатар хотод зохиогдсон “Нандин Өв” бий биелээчдийн наадамд оролцож “Хотон түмний авьяаслаг гэр бүл” өргөмжлөлөөр шагнагдсан.
 - 2007 онд бий биелгээний уламжлалыг хойч үедээ сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь үнэлж ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комиссын “өргөмжлөл”-өөр шагнагдсан.
 - 1991 онд Бүх ард түмний Урлагийн их наадмын II шатны шалгаруулалтад өндөр амжилт гаргасан учир Увс аймгийн “**Тэргүүний уран сайханч**” шагнагдсан.
 - 1987 онд МАХН-ын XIX их хурлын шийдвэрийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлж МҮЭ-ийн XIII их хурал, 60 жилийн ой угтаж зохиосон ажилчны урлагийн II их наадам, клубийн тайлан тоглолтд хадам аав Х.Түвдэнтэй хамт оролцож баярын бичгээр шагнагдсан.
 - 1984 онд Тээврийн байгууллага үүсэж хөгжсөний 50 жилийн ойн урлагийн үзлэгт ардын язгуур урлагийн бий биелгээний төрлөөр оролцож хүрэл медаль хүртсэн.
4. УРАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ
- 1994 онд Ойрдын их туульч М.Парчингийн хөрөг залах ардын язгуур урлагийн “Дуу хуурын эгшиглэн оршвой” анхдугаар уралдаанд гэр бүлийн хамт амжилттай оролцсон.
 - 2006 онд Увс аймгийн драмын театрт гэр бүлийн “Аяс” хамтлагийн “Цацал” тайлан тоглолтыг хийж сум орон нутгийн ард иргэдэд хүрэлцэн очиж тоглолтоо үзүүлсэн.
 - 2006 оны 12 сард “Хотон түмний дуулал” концертын туслах найруулагчаар ажиллаж, гэр бүлээрээ оролцсон.
 - 2007 онд Улаанбаатар хотод зохиогдсон морин хуурчдын 2-р их наадамд гэр бүлээрээ уригдан оролцсон.
 - 2011 онд Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл урлагийн хорооны дарга асан ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн гуайн санаачилж МҮОНТ-

ийн найруулагч н.Лхамсүрэнгийн бүтээл “Хотон ястны бий биелгээ” баримтат кинонд зөвлөх найруулагчаар ажилласан.


- 2013 Авьяас хөтөлбөрийн хүрээнд Дундговь, Өмнөговь аймгуудад бий биелгээний сургалтыг 2000 орчим хүүхдэд зааж сургасан.
- Жил бүр СУИС-ийн Бүжгийн Урлагийн сургуультай хамтарч дотоод, гадаадын оюутнуудад бий биелгээний сургалт явуулж жуулчдад сурталчлан таниулж байна.

4.1. УРАН БҮТЭЭЛИЙН ҮР ДҮНГИЙН ИЛЭРЦ

Д.Балган нь Хотон биелгээний өөрийн гэсэн уламжлалт дэг сургалтыг үүсгэхдээ хадам аав Х.Түвдэнгийн бий-биелгээг хийхэд биед нөлөөлөх нөлөө, мэдрэмж бүхнийг өөртөө бий болгох арга барилын уламжлан авч өдгөө хүртэл бусад ястны биелгээтэй харьцуулан судалж байна. Түүний бий биелгээний талаарх судалгааг хүү Ганзориг нь гүнзгийрүүлэн судалж 2018 онд Монголын Залуучуудын Холбооноос 24 дэх удаагаа зохион байгуулсан “Эврика-2018” эрдэм шинжилгээний улсын уралдаанд оюутан судлаачийн ангилалд “Бий биелгээ нь хүн байгалийн уялдаа холбоо болох нь” гэсэн илтгэлээр амжилттай оролцсон нь үр хүүхдүүддээ заан сургахаас гадна цаад нарын мөн чанар руу хэрхэн нэвтрэх, түүний амин чанарыг хэрхэн ойлгохын ухааныг өвлүүлэн уламжлуулж байгаа нь нэн сайшаалтай харагдаж байна.

Бага охин Цэнгэлийн хүү Тэмүүжин нь 2018 оны 11.24-нд Налайх дүүргийн соёлын төв, засаг даргын тамгын газар болон нийслэлийн соёл урлагийн газартай хамтран нийслэл болон Төв аймгийн ЕБС-дын сурагчдын дунд 9 дэх жилдээ зохион байгуулдаг “Бий биелгээ 2018” уралдаанд бага насны ангилалд гоцлол биелгээний төрөлд оролцож алтан медаль хүртэж мөн ондоо нагац аав Балгантай “Нүүдэлчин Монгол” соёлын биет бус өвийн их наадамд амжилттай оролцож 15 дахь үедээ өвлөн уламжилж байгаа улам нотолсоор байгаа билээ.

Тэрээр 2013 онд "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд Дундговь, Өмнөговь аймгуудын соёлын төв болон ерөнхий боловсролын сургуулийн ажилчин алба хаагч, сурагч нарт Хотон биелгээ болон бусад ястны бий биелгээг заан сургаж Монголын соёлын биет бус өв, тэр дундаа язгуур урлагийн нэг болох бий биелгээ гэж хэрхэн юу байдаг талаар амжилттай заан сургасан билээ.



2023 онд хүү Б.Ганзоригийн хамтаар “ҮЛ ТАСРАХ ӨВ” хотон угсаатны бий биелгээний сургалтын гарын авлагыг бүтээж олон нийтэд хотон бий биелгээг түгээн дэлгэрүүлэх ажлаа эрчимжүүлж байна. Энэ мэтээр өвлөн уламжлагч нар өөрийн гэсэн гарын авлага, судалгааны бүтээлийг олноор бий болгох тусам цаашид түүнийг судлах, түүнээс суралцах хүмүүс олшрох боломж бүрдэх юм.



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025. 12.30 № 01/8600

танай _____-ны № _____-т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА

“Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох тухай журам”-ын дагуу шалгуур үндэслэл хангаж буй өвлөн уламжлагчдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1. хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725141030

یصرتی یصرتی
نندھیں مر جسے صحتی



مصدق من الحق من مصنفهم و
مصدق من نسخهم في .. سرور و سرور

١٠٠
١٠١
١٠٢
١٠٣
١٠٤
١٠٥
١٠٦
١٠٧
١٠٨
١٠٩
١١٠
١١١
١١٢
١١٣
١١٤
١١٥
١١٦
١١٧
١١٨
١١٩
١٢٠
١٢١
١٢٢
١٢٣
١٢٤
١٢٥
١٢٦
١٢٧
١٢٨
١٢٩
١٣٠
١٣١
١٣٢
١٣٣
١٣٤
١٣٥
١٣٦
١٣٧
١٣٨
١٣٩
١٤٠
١٤١
١٤٢
١٤٣
١٤٤
١٤٥
١٤٦
١٤٧
١٤٨
١٤٩
١٥٠
١٥١
١٥٢
١٥٣
١٥٤
١٥٥
١٥٦
١٥٧
١٥٨
١٥٩
١٦٠
١٦١
١٦٢
١٦٣
١٦٤
١٦٥
١٦٦
١٦٧
١٦٨
١٦٩
١٧٠
١٧١
١٧٢
١٧٣
١٧٤
١٧٥
١٧٦
١٧٧
١٧٨
١٧٩
١٨٠
١٨١
١٨٢
١٨٣
١٨٤
١٨٥
١٨٦
١٨٧
١٨٨
١٨٩
١٩٠
١٩١
١٩٢
١٩٣
١٩٤
١٩٥
١٩٦
١٩٧
١٩٨
١٩٩
٢٠٠
٢٠١
٢٠٢
٢٠٣
٢٠٤
٢٠٥
٢٠٦
٢٠٧
٢٠٨
٢٠٩
٢١٠
٢١١
٢١٢
٢١٣
٢١٤
٢١٥
٢١٦
٢١٧
٢١٨
٢١٩
٢٢٠
٢٢١
٢٢٢
٢٢٣
٢٢٤
٢٢٥
٢٢٦
٢٢٧
٢٢٨
٢٢٩
٢٣٠
٢٣١
٢٣٢
٢٣٣
٢٣٤
٢٣٥
٢٣٦
٢٣٧
٢٣٨
٢٣٩
٢٤٠
٢٤١
٢٤٢
٢٤٣
٢٤٤
٢٤٥
٢٤٦
٢٤٧
٢٤٨
٢٤٩
٢٥٠
٢٥١
٢٥٢
٢٥٣
٢٥٤
٢٥٥
٢٥٦
٢٥٧
٢٥٨
٢٥٩
٢٦٠
٢٦١
٢٦٢
٢٦٣
٢٦٤
٢٦٥
٢٦٦
٢٦٧
٢٦٨
٢٦٩
٢٧٠
٢٧١
٢٧٢
٢٧٣
٢٧٤
٢٧٥
٢٧٦
٢٧٧
٢٧٨
٢٧٩
٢٨٠
٢٨١
٢٨٢
٢٨٣
٢٨٤
٢٨٥
٢٨٦
٢٨٧
٢٨٨
٢٨٩
٢٩٠
٢٩١
٢٩٢
٢٩٣
٢٩٤
٢٩٥
٢٩٦
٢٩٧
٢٩٨
٢٩٩
٣٠٠
٣٠١
٣٠٢
٣٠٣
٣٠٤
٣٠٥
٣٠٦
٣٠٧
٣٠٨
٣٠٩
٣١٠
٣١١
٣١٢
٣١٣
٣١٤
٣١٥
٣١٦
٣١٧
٣١٨
٣١٩
٣٢٠
٣٢١
٣٢٢
٣٢٣
٣٢٤
٣٢٥
٣٢٦
٣٢٧
٣٢٨
٣٢٩
٣٣٠
٣٣١
٣٣٢
٣٣٣
٣٣٤
٣٣٥
٣٣٦
٣٣٧
٣٣٨
٣٣٩
٣٤٠
٣٤١
٣٤٢
٣٤٣
٣٤٤
٣٤٥
٣٤٦
٣٤٧
٣٤٨
٣٤٩
٣٥٠
٣٥١
٣٥٢
٣٥٣
٣٥٤
٣٥٥
٣٥٦
٣٥٧
٣٥٨
٣٥٩
٣٦٠
٣٦١
٣٦٢
٣٦٣
٣٦٤
٣٦٥
٣٦٦
٣٦٧
٣٦٨
٣٦٩
٣٧٠
٣٧١
٣٧٢
٣٧٣
٣٧٤
٣٧٥
٣٧٦
٣٧٧
٣٧٨
٣٧٩
٣٨٠
٣٨١
٣٨٢
٣٨٣
٣٨٤
٣٨٥
٣٨٦
٣٨٧
٣٨٨
٣٨٩
٣٩٠
٣٩١
٣٩٢
٣٩٣
٣٩٤
٣٩٥
٣٩٦
٣٩٧
٣٩٨
٣٩٩
٤٠٠
٤٠١
٤٠٢
٤٠٣
٤٠٤
٤٠٥
٤٠٦
٤٠٧
٤٠٨
٤٠٩
٤١٠
٤١١
٤١٢
٤١٣
٤١٤
٤١٥
٤١٦
٤١٧
٤١٨
٤١٩
٤٢٠
٤٢١
٤٢٢
٤٢٣
٤٢٤
٤٢٥
٤٢٦
٤٢٧
٤٢٨
٤٢٩
٤٣٠
٤٣١
٤٣٢
٤٣٣
٤٣٤
٤٣٥
٤٣٦
٤٣٧
٤٣٨
٤٣٩
٤٤٠
٤٤١
٤٤٢
٤٤٣
٤٤٤
٤٤٥
٤٤٦
٤٤٧
٤٤٨
٤٤٩
٤٥٠
٤٥١
٤٥٢
٤٥٣
٤٥٤
٤٥٥
٤٥٦
٤٥٧
٤٥٨
٤٥٩
٤٦٠
٤٦١
٤٦٢
٤٦٣
٤٦٤
٤٦٥
٤٦٦
٤٦٧
٤٦٨
٤٦٩
٤٧٠
٤٧١
٤٧٢
٤٧٣
٤٧٤
٤٧٥
٤٧٦
٤٧٧
٤٧٨
٤٧٩
٤٨٠
٤٨١
٤٨٢
٤٨٣
٤٨٤
٤٨٥
٤٨٦
٤٨٧
٤٨٨
٤٨٩
٤٩٠
٤٩١
٤٩٢
٤٩٣
٤٩٤
٤٩٥
٤٩٦
٤٩٧
٤٩٨
٤٩٩
٥٠٠
٥٠١
٥٠٢
٥٠٣
٥٠٤
٥٠٥
٥٠٦
٥٠٧
٥٠٨
٥٠٩
٥١٠
٥١١
٥١٢
٥١٣
٥١٤
٥١٥
٥١٦
٥١٧
٥١٨
٥١٩
٥٢٠
٥٢١
٥٢٢
٥٢٣
٥٢٤
٥٢٥
٥٢٦
٥٢٧
٥٢٨
٥٢٩
٥٣٠
٥٣١
٥٣٢
٥٣٣
٥٣٤
٥٣٥
٥٣٦
٥٣٧
٥٣٨
٥٣٩
٥٤٠
٥٤١
٥٤٢
٥٤٣
٥٤٤
٥٤٥
٥٤٦
٥٤٧
٥٤٨
٥٤٩
٥٥٠
٥٥١
٥٥٢
٥٥٣
٥٥٤
٥٥٥
٥٥٦
٥٥٧
٥٥٨
٥٥٩
٥٦٠
٥٦١
٥٦٢
٥٦٣
٥٦٤
٥٦٥
٥٦٦
٥٦٧
٥٦٨
٥٦٩
٥٧٠
٥٧١
٥٧٢
٥٧٣
٥٧٤
٥٧٥
٥٧٦
٥٧٧
٥٧٨
٥٧٩
٥٨٠
٥٨١
٥٨٢
٥٨٣
٥٨٤
٥٨٥
٥٨٦
٥٨٧
٥٨٨
٥٨٩
٥٩٠
٥٩١
٥٩٢
٥٩٣
٥٩٤
٥٩٥
٥٩٦
٥٩٧
٥٩٨
٥٩٩
٦٠٠
٦٠١
٦٠٢
٦٠٣
٦٠٤
٦٠٥
٦٠٦
٦٠٧
٦٠٨
٦٠٩
٦١٠
٦١١

۵-۰۰ نکات و ملاحظات

[illegible]

1725091434

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
 12 дүгээр сарын 30-ны өдрийн
 01/8600 дугаар албан бичгийн
 хавсралт

ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ ӨВЛӨН
 УЛАМЖЛАГЧДЫН НЭРС

Д/д	Дүүрэг	Нэр дэвшигчдийн тоо	Нэр дэвшигчийн мэдээлэл
1	Баянгол дүүрэг	6	Гүен Балданцэрэн /ГЮ47020919/
2			Хонгор Уртнасан /ПЭ56091001/
3			Баасанхүү Цэрэндагва /НЭ90020515/
4			Далхаа Эрдэнэзуу /УУ65011351/
5			Төмөрхүү Батмөнх /ЧП46021533/
6			Равжаа Санжсүрэн /ОЭ53091572/
7	Баянзүрх дүүрэг	2	Алтангэрэл Дагзмаа /РЭ51110901/
8			Эрдэнэцогт Баатаржав /УС72031617/
9	Налайх дүүрэг	1	Энхтуяа Хүрэлбаатар /ДП75031311/
10	Сонгинохайрхан дүүрэг	1	Дурма Балган /ОЭ60072973/
11	Сүхбаатар дүүрэг	1	Дэндэв Баярхуяг /ХН71051917/
12	Чингэлтэй дүүрэг	1	Задь Цэнгэлсайхан /ТЖ56020501/
13	Хан-Уул дүүрэг	1	Лхагвасүрэн Лхамрагчаа /ОЮ81040814/